

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2024/18/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Б.Хуланхатан Утас: 99008827 Цахим хаяг: khulankhatanb@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024.03.27 № 426
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ГУРВАНБАЯН
ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
Ж.ЭНХХУЯГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Гурванбаян тосгоны Захирагч нь Орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг Захирагчийн ажлын албанд 566.0 мянган төгрөгөөр илүү олгосон, аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн байгууллагуудаас Захирагчийн ажлын алба нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 оны 06 -р сард Ариун-Агь ХХК-аас худалдаж авсан ковш тракторт баталгаат хугацаа дуусаагүй байхад 2023 оны 09 сард 5,000.0 мянган төгрөгийн мотор авсан, үндсэн үйл ажиллагааны зардлаас Эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмж, Соёлын төвд чанга яригч засварын хөлс, бараа ажил үйлчилгээний төлбөр хураамж, даатгалын үйлчилгээ, бараа үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас ХХОАТ төлж 9,957.5 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан зэрэг зөрчил илэрч, зөрчлийн дүн нь урьдчилан тооцсон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

20240534

Асуудлыг онцолсон хэсэг

Гурванбаян тосгоны Захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 111,469.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, 39,127.7 мянган төгрөгийн авлага, 695.8 мянган төгрөгийн урьдчилгаа, 82,996.6 мянган төгрөгийн бараа материал, 1,160,916.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 1,395,205.9 мянган төгрөг байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 392,984.4 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 175,753.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 608,032.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос ерөнхий орлогын дансанд 7,491.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд 8,243.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, бүрэн зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Гурванбаян тосгоны Захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар орон нутгийн төсвийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгож, шилэн дансны цахим сайтад мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж хуулийн хугацаанд ирүүлэх, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдлийг барагдуулахад анхаарч ажиллах шаардлагатай..

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхий лэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж. ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		239,106.00	234,289.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	132,639.60	111,469.90
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	49,216.00	39,127.70
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	695.80	695.80
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	56,554.70	82,996.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,205,648.60	1,160,916.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,205,648.60	1,160,916.00
39200	Биет хөрөнгө		1,183,356.60	1,138,624.00
39300	Биет бус хөрөнгө	13	22,292.00	22,292.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,444,754.60	1,395,205.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		3,766.50	143.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	3,766.50	143.90
41300	Өглөг	17а, 17б	3,766.50	143.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,440,988.10	1,395,062.00
51	Засгийн газрын хувь оролцоо		1,440,988.10	1,395,062.00
51100	Засгийн газрын оруулсан капитал		165,881.10	165,881.10
51200	Хуримтлагдсан үр дүн		1,103,222.90	1,057,296.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		171,884.20	171,884.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,444,754.60	1,395,205.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Кo	Тайлангийн үзүүлэлт	Тодруулг	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		1,402,570.80	1,305,736.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО		188,132.40	175,316.50
110	Орлогын албан татвар		136,497.90	129,516.70
1100	Хувь хүний орлогын албан татвар		136,497.90	129,516.70
113	Хөрөнгийн албан татвар		18,719.30	19,492.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж		32,915.20	26,307.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	334,533.70	65,413.60
120	Нийтлэг татварын бус орлого		334,533.70	65,413.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		879,904.70	1,065,006.40
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,059,172.20	1,286,686.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,059,172.20	1,286,686.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		548,613.80	665,681.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		138,685.90	190,843.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		17,450.30	23,423.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		234,072.30	37,121.50
2104	Хангамж, бараа материалын зардал		22,685.40	39,928.40
2105	Нормативт зардал		-	136.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		13,483.10	11,854.00
2107	Томилолт, зочны зардал		1,940.00	7,448.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		8,317.40	229,491.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		111,979.40	125,434.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		510,558.40	621,004.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		343,398.60	19,050.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		2,203,839.00	64,976.60
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		(1,860,440.30)	(45,926.10)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,348,587.10	3,348,587.10
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(47,158.60)	(47,158.60)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,301,428.40	3,301,428.40
9	Тайлант үеийн үр дүн	(1,860,440.30)	(1,860,440.30)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,440,988.10	1,440,988.10
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,440,988.10	1,440,988.10
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,440,988.10	1,440,988.10
19	Тайлант үеийн үр дүн	(45,926.10)	(45,926.10)
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	1,395,062.00	1,395,062.00

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,072,018.30	1,251,392.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	188,132.40	175,316.50
110	Орлогын албан татвар	136,497.90	129,516.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	136,497.90	129,516.70
113	Хөрөнгийн албан татвар	18,719.30	19,492.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж	32,915.20	26,307.70
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,208.10	3,444.30
1181	Газрын төлбөр	29,707.00	22,863.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,981.20	4,609.50
120	Нийтлэг татварын бус орлого	3,981.20	4,609.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	879,904.70	1,071,466.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	960,108.80	1,204,175.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	960,108.80	1,204,175.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	437,573.10	583,170.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	137,837.50	188,652.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,767.40	22,814.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	230,202.80	41,574.10
2104	Хангамж, бараа материалын зардал	11,190.90	32,960.20
2105	Нормативт зардал	126.20	9,142.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,520.20	29,630.60
2107	Томилолт, зочны зардал	1,940.00	7,448.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,067.40	230,232.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,920.80	20,715.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	522,535.70	621,004.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	111,909.40	47,216.90
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	46,658.70	68,386.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,658.70	68,386.60
2200	Дотоод эх үүсвэрээр	46,658.70	68,386.60
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(46,658.70)	(68,386.60)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	65,250.70	(21,169.70)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	67,388.80	132,639.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	132,639.60	111,469.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	685,057.60	647,794.62	37,262.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	590,343.10	582,818.00	7,525.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	579,582.30	578,557.20	1,025.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,652.70	188,652.70	0.00
210101	Үндсэн цалин	152,688.20	148,420.01	4,268.19
210102	Нэмэгдэл	25,322.20	27,794.16	(2,471.96)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,197.20	4,719.03	(1,521.83)
210105	Гэрээт ажлын хөлс	7,445.10	4,604.36	2,840.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,814.10	22,814.10	-
210201	Тэтгэврийн даатгал	15,513.60	13,038.90	2,474.70
210202	Тэтгэмжийн даатгал	1,825.10	4,640.33	(2,815.23)
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,460.10	1,525.79	(65.69)
210204	Ажилгүйдлийн даатгал	365.00	556.91	(191.91)
210205	Эрүүл мэндийн даатгал	3,650.30	3,052.17	598.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	255,347.80	255,112.23	235.57
210301	Гэрэл, цахилгаан	28,330.00	25,711.17	2,618.83
210302	Түлш, халаалт	220,081.80	221,982.46	(1,900.66)
210303	Цэвэр, бохир ус	6,936.00	7,418.60	(482.60)
2104	Хангамж, бараа материалын зардал	26,203.30	26,016.70	186.60
210401	Бичиг хэрэг	5,883.60	5,883.60	-
210402	Тээвэр, шатахуун	11,057.20	11,057.20	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,693.60	3,557.00	136.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,568.90	5,518.90	50.00
2105	Нормативт зардал	9,151.30	9,142.40	8.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,151.30	9,142.40	8.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,061.60	43,040.46	21.14
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,926.50	16,926.50	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,135.10	1,118.20	16.90
210604	Урсгал засвар	25,000.00	24,995.76	4.24
2107	Томилолт, зочны зардал	7,858.10	7,448.00	410.10
210702	Дотоод албан томилолт	7,858.10	7,448.00	410.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,157.20	6,094.91	62.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,407.50	3,407.50	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	31.50	31.50	-
210803	Даатгалын үйлчилгээ	294.80	294.80	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	287.60	262.51	25.09
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	74.00	74.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,061.80	2,024.60	37.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,336.20	20,235.70	100.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,000.00	16,899.50	100.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,336.20	3,336.20	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,760.80	4,260.80	6,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,760.80	4,260.80	6,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,000.00	-	5,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,760.80	4,260.80	1,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	94,714.50	64,976.61	29,737.89
223001	Бусад хөрөнгө	94,714.50	64,976.61	29,737.89
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	685,057.60	659,428.86	25,628.74
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	664,457.60	655,256.35	9,201.25
320001	Орон нутгийн төсвөөс	609,743.10	600,541.85	9,201.25
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	54,714.50	54,714.50	-

35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,600.00	4,172.50	16,427.50
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600.00	-	600.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	20,000.00	-	20,000.00
4	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	48,574.01	(48,574.01)
5	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	60,208.25	(60,208.25)

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,243.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,243.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,023.46
2104	Хангамж, бараа материалын зардал	6,943.46
210402	Тээвэр, шатахуун	4,893.46
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,050.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	480.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	220.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	220.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	220.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,243.46
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,243.46
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,243.46
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

Гурав. Аудитын илрүүлэлт: Гурванбаян тосгоны Захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 5 байгууллага, 1 төрийн сан, 3 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвд “ИХНАЯД АУДИТ” ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн. Аймаг дахь Төрийн аудитын газар Захирагчийн ажлын алба, Соёлын төв, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн санг аудитын түүвэрт хамруулсан.

3.1 Тус сумын харьяа орон нутгийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар:

Харьяа орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 14,957.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 5,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 9,957.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

Захирагчийн ажлын алба

1. ОНХС-ын хөрөнгөөр 2023 оны 06 -р сард Ариун-Агь ХХК-аас худалдаж авсан ковш тракторт баталгаат хугацаа дуусаагүй байхад 2023 оны 09 сард 5,000.0 мянган төгрөгийн мотор авсан.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

2. Үндсэн үйл ажиллагааны зардлаас Эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмж, Соёлын төвд чанга яригч засварын хөлс, бараа ажил үйлчилгээний төлбөр хураамж, даатгалын үйлчилгээ, бараа үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас ХХОАТ төлж 9,957.5 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

3.2 Тус сумын харьяа улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 919,064.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,530.0 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 275.8 мянган төгрөгийг зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 115,360.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 799,898.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 5 зөвлөмж өгсөн байна. Үүнд:

Соёлын төв

1. Үнэ төлбөргүй хүлээн авсан 2,680 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 850.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авч данс бүртгэлд тусгаагүй алдааг санхүүгийн тайланд залруулав.
2. Тушаал, шийдвэргүйгээр 275.8 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Ерөнхий боловсролын сургууль

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд цалингийн зардлыг илүү тайлагнаж, төлсөн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

2. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 55 нэр төрлийн үндсэн хөрөнгийг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

3. Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 562,594.6 мянган төгрөгийн 21 гүйлгээг мэдээлэхээс 516,000.8 мянган төгрөгийн 19 гүйлгээг дутуу, зарлагын 79,870.7 мянган төгрөгийн 9 гүйлгээг мэдээлэхээс 10,553.0 мянган төгрөгийн мэдээллийг илүү мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Хүүхдийн цэцэрлэг

1. Ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 115.1 мянган төгрөгийг ерөнхий журналд дутуу тусгаж, тайлагнасан.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

2. Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 231,069.0 мянган төгрөгийн 11 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Эрүүл мэндийн төв

1. Эм боох материалын зарлагыг эхэлж авснаа эхэлж зарлагадаагүй 6,120.0 мянган төгрөгийн хуучин эмийн үлдэгдэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн

2. Бараа материал дансанд 22,847.2 мянган төгрөгийн бараа материалыг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого, зарлагаар бүртгэхгүйгээр бөөн дүнгээр бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн

3. Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 114,875.7 мянган төгрөгийн гүйлгээ мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Хүснэгт 10. Зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил								
Сургууль	2	484.7			1	484.7	1	-
Цэцэрлэг	1	115.1					1	115.1
ЭМТөв	2	6,120.0					2	6,120.0
Соёлын төв	1	275.8	1	275.8				
Дүн	6	6,995.6	1	275.8	1	484.7	4	6,235.1
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Сургууль	1	562,594.6					1	562,594.6
Цэцэрлэг	1	231,069.0					1	231,069.0
ЭМТөв	2	114,875.7			2	114,875.7		
Дүн	4	908,539.3	-	-	2	114,875.7	2	793,663.6
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	10	915,534.9	1	275.8	3	115,360.4	6	799,898.7

3.3 Тосгоны Захирагчийн санхүүгийн нэтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Гурванбаян тосгоны Захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 1,434,126.1 мянган төгрөгийн 2 зөрчил илэрч, 566.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,433,560.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

3.3.1 Төлбөрийн акт

Байхгүй

3.3.2 Албан шаардлага

Орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг Захирагчийн ажлын албанд 566.0 мянган төгрөгөөр илүү олгосон.

3.3.3 Зөвлөмж

Шилэн дансны цахим сайтад мэдээлбэл зохих цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 399,484.4 мянган төгрөгийн 13 гүйлгээ, зарлагын 939,361.2 мянган төгрөгийн 46 гүйлгээг мэдээлээгүй, тендер шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх 94,714.5 мянган төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	0	-	0	-	0	-	0	-				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан		Хууль, хяналтын байгууллагад		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ТТЗ	1	566.0			1	566.0							
ЗАА	2	14,957.5	1	5,000.0	1	9,957.5							
Дүн	3	15,523.5	1	5,000.0	2	10,523.5	-	-					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
ЗАА	1	1,433,560.1							1	1,433,560.1
	-	-								
Дүн	1	1,433,560.1								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	8	3	4	1	3			
2	ОНӨААН								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
	НИЙТ	9	4	4	1	3	1		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25

Дугаар 120-АД/270452
ХТА-2024/18/НА-СТА-ТЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн төсвийн санхүүжилтийг Захирагчийн ажлын албанд батлагдсан төсвийн хуваариас 566.0 мянган төгрөгөөр илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8-д "төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдаг этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Санхүүжилтийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу олгодоггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тосгоны захирагч Ж.Энххуяг, санхүүгийн албаны дарга Ц.Саранцэцэг нар т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.ХУЛАНХАТАН

